Шүдний гаралтай эрүүний ясны архаг үхжилт үрэвслийн тохиолдлыг судалсан дүн

П.Булган[1], Ц.Ариунтунгалаг[1], М.Болд[1], Э.Уламбаяр[1], Г.Баярмөнх[1], У.Түмэндэлгэр[1], П.Даваадорж[1]

[1]Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг, Эрүү Нүүрний Мэс Засал
Email:ts.aagii@mail.ru, Утас: 95400035

Түлхүүр үг:
Эрүүний ясны архаг үхжилт үрэвсэл
Секвестрэктомия

Товч утга: Эрүү нүүр орчмын өвчлөл дундаас үрэвсэлт өвчин дийлэнх хэсгийг эзэлж байна. Сүүлийн жилүүдэд чихрийн хэрэглээ ихсэж, амны хөндийн эрүүл ахуйн талаар олон нийтийн дунд мэдлэг дутмаг байгаагаас шалтгаалан шүдний цоорлын тархалт өндөр хувьтай байгаа ба шүдийг цаг тухайд нь эмчлүүлээгүйгээс цаашид идээт үрэвсэл, буглаа, ясны хальсны үрэвсэл, шүдний гаралтай нэвчээс, ясны идээт үхжилт үрэвсэл, голтын үрэвсэл зэргээр хүндэрч амь насаа алдахад хүргэдэг байна. Иймд амны хөндийн эрүүл ахуйгаа сайтар сахих шүдний цоорлыг цаг тухайд нь эмчлүүлэх, шүдний цоорлоос сэргийлэх зэрэг нь эрүүний ясны архаг үхжилт үрэвсэл болон бусад хүндрэлүүдээс сэргийлэх чухал ач холбогдолтой юм. Шүдний гаралтай эрүүний ясны архаг үхжилт үрэвслийнталаар судалгаа сүүлийн жилүүдэд хийгдээгүй нь энэхүү судалгааны ажлыг хийх үндэслэл болсон юм. Судалгаандаа шүдний гаралтай эрүүний ясны архаг үхжилт үрэвслийн тохиолдлыг судлах зорилго тавьж, 2016-2017 оны хооронд Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг, Эрүү Нүүрний Мэс Заслын тасагт шүдний гаралтай эрүүний ясны архаг үхжилт үрэвсэл гэж оношлогдсон судалгаанд оруулах шалгуурыг хангасан 205 үйлчлүүлэгчдийн өвчний түүхийг судалгааны картанд тэмдэглэж, SPSS 22.0 программ ашиглан статистик боловсруулалт хийж үр дүнг тооцлоо. Судалгааны үр дүнгээс авч үзвэл шүдний гаралтай эрүүний ясны архаг үхжилт үрэвсэлтэй эрэгтэй үйлчлүүлэгчдийн дундаж нас нь 36.5 ± 15.2 нас байхад, эмэгтэй үйлчлүүлэгчдийн дундаж нас нь 22.4 ± 15.0 нас байлаа. Эрэгтэй үйчлүүлэгчдийн дунд 35-51 насныхан хамгийн их хувийг (46%) эзэлж байхад, 52 дээш насныхан 3%, эмэгтэй үйлчлүүлэгчдийн дунд 18-34 насныхан (50%) бөгөөд эзэлж байсан ба 35-51 насныхан 25% эзэлж байлаа. Байрлалын хувьд авч үзвэл эрүүний бие болон буланд хамгийн их буюу (91%), баруун талд (56%) нь зүүн талд (44%) тус тус тохиолджээ.Судалгаанаас хамрагдагсад хүйсийн хувьд ялгаатай буюу эмэгтэй үйлчлүүлэгчид (34%), эрэгтэй үйлчлүүлэгчид (66%) буюу эрэгтэй хүмүүст илүү тохиолдож байна.


Үндэслэл: Дэлхий дахинд сүүлийн үед эрүүний ясны үхжилт үрэвсэл буюу остеомиелит нь микробын эсрэг эмийн эмчилгээ болон эрүүл мэндийн тусламж үйлчилгээ сайжирсантай холбоотойгоор тохиолдлын тоо өмнөх жилүүдтэй харьцуулахад буурч байна.Гэсэн хэдий ч эмийн зохисгүй хэрэглээ, амны хөндийн эрүүл ахуйн талаарх мэдлэг дутмаг, антибиотикт тэсвэртэй болох, микробын хоруу чанар, тэжээлийн дутагдал зэргээс хамаарч эрүүний ясны үхжилт үрэвсэл зарим улс орнуудад тохиолдлын тоо буурахгүй байна. Хувь хүний бие махбодийн онцлогийн хувьд эрүүний ясны архаг үхжилт үрэвсэл үүсэхэд дараах хүчин зүйлс байна. Үүнд: микробын хоруу чанар, эзэн биеийн хариу урвал хамгаалах болон тэсвэрлэх чанар, судасны хамгаалах чадвар нөлөөлдөг.[1,2]

Эрүүний ясны архаг үхжилт үрэвсэл хоншоорынхоос илүү тохиолддог нь ясны бүтэц болон судасжилт зэргээс эрүүний яс нь цусан хангамж бага мөн ясны эд нь зузаан зэрэг хүчин зүйлээс хамаардаг.[3]

Эмчилгээний хувьд эрүүний ясны архаг үхжилт үрэвслийн үед эмийн болон мэс заслын эмчилгээг хавсарч эмчлэх эмчилгээний арга чухал юм [4].


Арга аргачлал: Уг судалгааг Улсын Нэгдүгээр Төв Эмнэлэг (УНТЭ)-ийн өвчний түүх ашиглан ретроспективдескриптив судалгааны загвараар хийж гүйцэтгэв. Эрүүний ясны архаг үхжилт үрэвслийн тохиолдлыг судлах зорилгоор УНТЭ-ийн Эрүү Нүүрний Мэс Заслын тасагт 2016-2017 онд К10.3 олон улсын өвчний кодын дагуу хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгчдийн 205 өвчний түүхийг ялган авч, судалгааг явуулах тусгай боловсруулсан судалгааны картаар нас, хүйс, эмнэлзүйн байдал зэргийг тэмдэглэж гарсан үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийв. Судалгааны ажлын үр дүнг тооцож, боловсруулахад Microsoft excel 2007, SPSS 22.0 программ ашиглан гүйцэтгэв. Статистик боловсруулалтыг үнэлэхдээ $p<0.05$ байгаа тохиолдолд статистикийн үнэн магадлалтай гэж үзсэн.

Үр дүн: Судалгаанд оруулах шалгуурт тэнцсэн өвчний түүхэнд дүн шинжилгээ хийж дараах үр дүнд хүрлээ.



Зураг 1. Эрүүний ясны архаг үхжилт үрэвсэлтэй үйлчлүүлэгчдийн насыг хүйсээр судалсан байдал

Зураг 1-с Судалгаанд хамрагдсан нийт 205 тохиолдлыг насны хувьд авч үзвэл 18-34 насанд хамгийн их буюу эмэгтэй 50% байхад эрэгтэй 35-51 насанд 46% тохиолдож байхад ($p<0.05$), 52 дээш насанд эрэгтэй, эмэгтэй хүйсэнд ойролцоо 23%, 25% тус тус тохиолджээ.



Зураг 2. Судалгаанд хамрагсдын дундаж нас

Зураг 2-с эрүүний ясны архаг үхжилт үрэвсэлтэй эрэгтэй үйлчлүүлэгчдийн дундаж нас нь 36.5 ± 15.2 нас байхад, эмэгтэй үйлчлүүлэгчдийн дундаж нас нь 22.4 ± 15.0 нас байлаа.



Зураг 3. Судалгаанд хамрагсдыг харьяаллалаар судалсан байдал

Зураг 3-аас харахад судалгаанд хамрагдсдын 40% нь Улаанбаатар хотынх, 60% нь хөдөө орон нутгийнхан байв. Шалтгаан болж буй шүдний хувьд хамгийн их буюу (45%) нь нэгдүгээр их арааны цоорлын хүндрэлээс үүссэн байна. Үйлчлүүлэгчдийн эмнэлэгт хэвтсэн дундаж ор хоног 10.5 ± 3.24 байв.

Хэлцэмж: Эрүүний ясны архаг үхжилт үрэвсэл нь эрүү нүүрний мэс заслын эмч нарт илүү олон давтамжтай тулгардаг архаг шүдний халдварын гаралтай хүндрэлээр тайлбарлагддаг.[5-7]

Бидний судалгаанд эрэгтэй үйлчлүүлэгчид (66%) эмэгтэй үйлчлүүлэгчид (34%), эрэгтэй үйлчлүүлэгчдийн дундаж нас нь 36.5±5.2, эмэгтэй үйлчлүүлэгчдийн дундаж нас нь 22.4±15.0 нас байсан нь судлаач SU-Gwan Kim-ийн судалгаагаар[8] эрүүний ясны архаг үхжилтэд үрэвсэлтэй эрэгтэй үйлчлүүлэгчийн эзлэх хувь 63.3%, эмэгтэй үйлчлүүлэгчийнх 36.3% байсантай харьцуулахад ойролцоо үзүүлэлттэй харин 50-59 насныханд хамгийн их тохиолдсон байсан нь бидний судалгааны дүнгээс өндөр байна.

Эрүүний ясны архаг үрэвсэлт үхжит үрэвслийн хамгийн түгээмэл шалтгаан бол шүдний гаралтай халдвартай шууд холбоотой (91.5%), амны хөндийн үрэвсэл (9.52%), шүдний тулгуур эдийн үрэвсэл (14.28%) болон буйлны үрэвсэл (9.52%) тус эзэлдэг. Энэхүү ялгаа нь амны хөндийн эрүүл мэндийн мэдлэг дутуу, шүдний цоорлыг цаг тухайд нь эмчлүүлээгүйгээс болдог байна.[9]

Дүгнэлт: Эрүүнй ясны архаг үхжилт үрэвсэл эрэгтэй үйлчлүүлэгчдийн дундаж нас нь 36.5±15.2 нас байхад, эмэгтэй үйлчлүүлэгчдийн дундаж нас нь 22.4±15.0 насанд хамгийн их тохиолдсон байна. Шалтгаан болж буй шүдний хувьд хамгийн их буюу (45%) нь нэгдүгээр их арааны цоорлын хүндрэлээс үүссэн байна. Үйлчлүүлэгчдийн эмнэлэгт хэвтсэн дундаж ор хоног 10.5±3.24 байлаа.

Ном зүй:

1. *WimalawansaSJ.Bisphosphonate-associated osteomyelitis of the jaw: guidelines for practicing clinicians.EndocrPract. 2008 Dec;14(9):1150-68.*
2. *Andre CV, Khonsari RH, Ernenwein D, Goudot P, Ruhin B. Osteomyelitis of the jaws: A retrospective series of 40 patients. JStomatol Oral Maxillofac Surg. 2017 Oct;118(5):261-264. doi: 10.1016/j.jormas.2017.04.007.*
3. *Adekeye EO, Cornah J. Osteomyelitis of the jaws: a review of 141 cases. Br J Oral Maxillofac Surg. 1985 Feb;23(1):24-35.*
4. *Patel V, Harwood A, McGurk M. Osteomyelitis presenting in two patients: a challenging disease to manage. Br Dent J. 2010; 209: 393-396.*

5. *Humber CC, Albilia JB, Rittenberg B. Chronic osteomyelitis following an uncomplicated dental extraction J Can Dent Assoc. 2011; 77: b98.*
6. *Nezafati S, Ghavimi MA, Yavari AS. Localized osteomyelitis of the mandible secondary to dental treatment: report of a case. J Dent Res Dent Clin Dent Prospects. 2009; 3: 67-69.*
7. *Urade M, Noguchi K, Takaoka K, Moridera K, Kishimoto H. Diffuse sclerosingosteomyelitis of the mandible successfully treated with pamidronate: a long-term follow-up report. Oral Surg Oral Med Oral Pathol Oral Radiol. 2012. 114: 9-12.*
8. *Kim SG, HS Jang. Treatment of chronic osteomyelitis in Korea. Oral Surg Oral Med Oral Pathol Oral RadiolEndod. 2001. 92: 394-398.*
9. *Chronic osteomyelitis of the mandible: A comparative study of 10 cases with primary chronic osteomyelitis and 12 cases with secondary chronic osteomyelitis.*

Fact finding study the chronic osteomyelitis of the jaw

Bulgan P[1], Ariuntungalag Ts[1], Bold M[1], Ulambayar E[1], Bayarmunkh G[1], Tumendelger U[1], Davaadorj P[1]

[1]First Central Hospital of Mongolia, Department of Oral and Maxillofacial surgery
Email:ts.aagii@mail.ru, Tel: 95400035

Background: The osteomyelitis of the jaws is a common disease but dreadful due to its need for prolonged therapy, which sometimes results in disfigurement and dysfunction of the affected area. In the recent past, the occurrence of osteomyelitis of the jaws has declined because of the availability of newer antimicrobial agents and also improved dental care. We purposed to study the epidemiological record (sex, age, ethnic background, risk factors, clinical, origin of disease, imaging and biology, treatments and progression) were collected for each patient of the chronic osteomyelitis of the jaw and the retrospective study involved 205 patients with the diagnosis of osteomyelitis of the jaw and they were treated at The First Central Hospital of Mongolia during 2016-2017. We registered patients' histories in special cards and performed statistical analysis SPSS 22. The study shows that the occurrence of osteomyelitis of the jaws has sex difference or males suffer from it mostly ($p<0.05$).